



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/409

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
87 дугаар сургуулийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүрээ ротари” клуб, Японы Осаки Ийст ротари клуб болон эцэг эхчүүдээс хандивласан нийт 22,724,990.00 (хорин хоёр сая долоон зуун хорин дөрвөн мянга есөн зуун ер) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 87 дугаар сургууль (Л.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 87 дугаар сургууль (Л.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны 11 дугаар сарын 07-ны
өдрийн 418 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 87 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Зурагт	Smart	43 инч	2024	Сайн	ш	1	500,000.00	500,000.00	Эцэг эхчүүд	Хандив
2	Зурагт	Monel	43 инч	2024	Сайн	ш	1	550,000.00	550,000.00		
3	Зурагт	Samsung	46 инч	2024	Сайн	ш	1	590,000.00	590,000.00		
4	Зурагт	Samsung	55 инч	2024	Сайн	ш	1	880,000.00	880,000.00		
5	Зурагт	Samsung	60 инч	2024	Сайн	ш	1	1,000,000.00	1,000,000.00		
6	Зурагт	Enjoy	50 инч	2024	Сайн	ш	1	949,990.00	949,990.00		
Тоног төхөөрөмжийн дүн							6		4,469,990.00		
1	Шкаф /ком/	ДСП хавтан	Цагаан	2024	Сайн	ш	1	2,500,000.00	2,500,000.00	Багш, ажиллагсад	"Хүрээ ротари" клуб, Японы Осаки Ийст ротари клубуудын хамтарсан төсөл
2	Ширээ /текк/	ДСП хавтан	Хүрэн	2024	Сайн	ш	1	1,300,000.00	1,300,000.00		
3	Тавиур /ком/	ДСП хавтан	Шаргал	2024	Сайн	ш	2	1,800,000.00	3,600,000.00		
4	Сурагч ширээ	Модон төмөр хөлтэй	Шаргал	2024	Сайн	ш	17	180,000.00	3,060,000.00		
5	Сурагч сандал	Модон төмөр хөлтэй	Шаргал	2024	Сайн	ш	31	80,000.00	2,480,000.00		
6	Ханын тавиур	ДСП хавтан	Шаргал	2024	Сайн	ш	2	1,532,000.00	3,064,000.00		
7	Ханын тавиур	ДСП хавтан	Шаргал	2024	Сайн	ш	1	1,901,000.00	1,901,000.00		
8	Ширээ /компьютерийн/	ДСП хавтан	Шаргал	2024	Сайн	ш	1	350,000.00	350,000.00		
Тавилга, эд хогшлын дүн							56		18,255,000.00		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн							62		22,724,990.00		